



2019 оны 07 дугаар сарын 23
№28 /1081/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

**Харилцаа холбооны тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

Монгол Улсын
хууль

**Шуудангийн тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай**

Монгол Улсын
хууль

**Радио долгионы тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

257.	Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1046
258.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1053
259.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1054
260.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1055
261.	Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1055
262.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1059
263.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1060
264.	Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1060
265.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1064
266.	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай	1064
267.	“Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын болон Оросын Холбооны Улсын Засгийн газрын хооронд байгуулсан хэлэлцээрийг соёрхон батлах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1066
268.	Протокол соёрхон батлах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1066
269.	Протокол соёрхон батлах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1067
270.	Хэлэлцээр соёрхон батлах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1067
271.	Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1068



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.14-3.1.20 дахь заалт:

3.1.14. “мэдээллийн технологи” гэж компьютер, харилцаа холбооны сүлжээ ашиглан цахим өгөгдлийг үүсгэх, боловсруулах, хадгалах, дамжуулах, солилцох, үйлчилгээ үзүүлэх, бусад тоног төхөөрөмжтэй холбогдох, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг;

3.1.15. “зохицуулалт” гэж мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, шилжүүлэх болон тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоохтой холбоотой журам батлах, гэрээ байгуулах, хяналт тавих, хууль тогтоомжид заасан асуудлаар шийдвэр гаргахтай холбогдсон цогц үйл ажиллагааг;

3.1.16. “домэйн нэр” гэж интернетийн нөөцийн хаягийг тодорхойлох тухайн улсад тусгайлан олгосон үсэг, тоо, бусад таних тэмдгийн хослолыг;

3.1.17. “норматив баримт бичиг” гэж харилцаа холбооны үйл ажиллагааг явуулах шаардлагыг агуулсан норм, дүрэм, заавар, аргачлалыг;

3.1.18. “харилцан холболт” гэж хоёр үйлчлэгчийн сүлжээ хоорондын холболтыг;

3.1.19. “сүлжээнд холбогдох” гэж үйлчлэгч нь өөрийн үйлчилгээг хэрэглэгчид хүргэх зорилгоор сүлжээ бүхий үйлчлэгчийн сүлжээнд холбогдохыг;

3.1.20. “баталгаажуулах” гэж харилцаа холбооны тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн тогтоосон шаардлагад нийцэж байгааг итгэмжлэгдсэн эрх бүхий этгээд бичгээр тодорхойлохыг.”

2/5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.5 дахь заалт:

“5.1.4.харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийг батлах, хэрэгжилтийг зохион байгуулах;

5.1.5.харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн өндөр технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бодлогын судалгаа шинжилгээний байгууллагын дүрэм, зардлыг санхүүжүүлэх журмыг батлах.”

3/6 дугаар зүйлийн 6.1.14-6.1.17 дахь заалт:

“6.1.14.харилцаа холбоо, мэдээллийн технологитой холбогдсон дараахь журмыг батлах:

6.1.14.а.төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам;

6.1.14.б.захиргааны байгууллагын цахим мэдээллийн санг байршуулах, шинэчлэх, хадгалах, түүхчилсэн бүртгэл үүсгэх, ашиглах журам;

6.1.14.в.төрөөс иргэдэд хүргэх радио, телевизийн нэвтрүүлгийг дамжуулах үйлчилгээний журам;

6.1.14.г.интернетийн дундын холболтын журам.

6.1.15.Энэ хуулийн 5.1.4-т заасан баримт бичигт дараахь бодлогын асуудлыг тусгана:

6.1.15.а.харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх талаарх мэдлэг, боловсролыг бүх нийтэд эзэмшүүлэх;

6.1.15.б.бусад салбарын болон салбар хоорондын харилцаа холбоо, мэдээллийн технологийн хэрэглээ, төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах;

6.1.15.в.харилцаа холбоо, мэдээллийн технологийн инноваци, үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

6.1.15.г.харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах;

6.1.15.д.төрийн байгууллагын үйл ажиллагаа болон харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн судалгаа шинжилгээний ажлын харилцан уялдааг хангах;



6.1.15.е.үндсэн сүлжээний оновчтой бүтцийг бий болгох, техник, технологи нэвтрүүлэх;

6.1.15.ж.бусад.

6.1.16.энэ хуулийн 5.1.4-т заасан хөтөлбөрийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;”

6.1.17.харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах.”

4/6¹ дүгээр зүйл:

“6¹ дүгээр зүйл.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн талаарх салбар хоорондын үйл ажиллагаа

6¹.1.Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологи нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байна.

6¹.2.Дараахь байгууллага харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна:

6¹.2.1.төрийн захиргааны төв байгууллага, тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байхгүй бол төрийн захиргааны байгууллага;

6¹.2.2.Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага;

6¹.2.3.Шүүхийн ерөнхий зөвлөл;

6¹.2.4.Улсын ерөнхий прокурорын газар.

6¹.3.Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага Засгийн газраар шийдвэрлүүлэх харилцаа холбоо, мэдээллийн технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн хүрээний асуудлаар харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг авсан байна.

6¹.4.Салбар хооронд харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх бодлого,

төлөвлөлтийн асуудлыг харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

6¹.5.Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний дараагийн жилийн эхний улиралд багтаан харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

6¹.6.Харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хэрэгжилтэд харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 20.2-т заасан журмын дагуу дөрвөн жилд нэг удаа үнэлгээ хийнэ.”

5/9 дүгээр зүйлийн 9.1.14-9.1.16 дахь заалт:

“9.1.14.домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбогдсон журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

9.1.15.тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэх харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам батлах;

9.1.16.Зохицуулах хорооны төсөв, ажлын албаны жилийн төлөвлөгөөг батлах.”

6/25 дугаар зүйлийн 25.2.10-25.2.12 дахь заалт:

“25.2.10.зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх;
25.2.11.хэрэглэгчийг регистрийн дугаараар бүртгэх;
25.2.12.бусад үйлчлэгчид ижил нөхцөлөөр үйлчлэх;”

7/27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалт:

“27.1.4.нийтийн үйлчилгээний харилцаа холбооны сүлжээний хэвийн ажиллах нөхцөлийг хангах.”

8/27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг:

“27.2.Нийтийн үйлчилгээний харилцаа холбооны сүлжээг хувийн өмчлөл, эзэмшил, нийтийн эдэлбэрийн газар, барилга байгууламж болон нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн



хэсгээр дамжуулан гэрээний үндсэн дээр байрлуулж болох бөгөөд энэ тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага харилцаа холбооны тоног төхөөрөмж дээр ажиллах зөвшөөрлийг саадгүй олгох үүрэгтэй.”

9/30 дугаар зүйлийн 30.3, 30.4 дэх хэсэг:

“30.3.Харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад харилцаа холбооны улсын байцаагч ажиллаж болно.

30.4.Зохицуулах хороо болон харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ажиллах улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 10.4-т заасны дагуу олгоно.”

10/30¹ дүгээр зүйл:

“30¹ дүгээр зүйл.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит

30¹.1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудитыг харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас эрх авсан иргэн, хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.

30¹.2.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх иргэн, хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журам, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх аргачлалыг харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

30¹.3.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэх захиргааны байгууллагын жагсаалтыг Засгийн газар батална.

30¹.4.Энэ хуулийн 30¹.3-т заасан жагсаалтад хамаарах байгууллага хоёр жил тутам харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлсэн тайлангаа харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлж, тайланг олон нийтэд нээлттэй, ил тод байлгана.

30¹.5.“Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит” гэж тухайн байгууллагад ашиглаж байгаа харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, техникийн шийдэл, харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр нь байгууллагын стратегийн зорилтыг хангахад дэмжлэг үзүүлж, стандартад нийцэж байгаа эсэхийг хөндлөнгийн этгээдээс тогтоож, дүгнэлт, зөвлөмж гаргах хараат бус үйл ажиллагааг ойлгоно.



30¹.6.Төрийн аудитын байгууллагаас захиргааны байгууллагын үйл ажиллагаанд аудит хийхтэй холбогдсон харилцаанд энэ зүйл хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “утас,” гэсний дараа “радио долгион,” гэж, “цамхаг” гэсний дараа “, байр, талбай” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “Зохицуулах хороо” гэсний дараа “харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын “холболт хийх” гэсний дараа “, сүлжээнд холбогдох” гэж, “батлах” гэсний дараа “, хэрэгжилтэд хяналт тавих” гэж, 9.1.5 дахь заалтын “давамгайлж буй” гэсний өмнө “зүй ёсны монополь болон” гэж, “хянах” гэсний дараа “, батлах” гэж, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “тоног төхөөрөмж” гэсний дараа “, холбогдох эрхээр баталгаажсан программ хангамж” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Харилцаа холбооны тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалт:

“6.1.2.харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, биелэлтийг зохион байгуулах;

6.1.3.харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, давамгайл байдлаа сөргөөр ашиглахыг хязгаарлаж, өрсөлдөөнийг дэмжихэд баримтлах чиглэл, шинэ технологи нэвтрүүлэхтэй холбогдсон журам, заавар, аргачлал батлах, хэрэгжилтийг зохион байгуулах;”

2/6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалт:

“6.1.10.үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;”

3/8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг:

“8.7.Зохицуулах хороонд харилцаа холбооны улсын байцаагч ажиллана.”

4/9 дүгээр зүйлийн 9.1.2, 9.1.3, 9.1.10 дахь заалт:

“9.1.2.хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;



9.1.3.харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулах, холбогдох техникийн нөхцөл, шаардлага, норматив баримт бичиг, журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих;”

9.1.10.радио, телевизийн болон тэдгээрийг дамжуулах үйлчилгээний нөхцөл, шаардлагыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;”

5/12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг:

“12.1.Зохицуулах хороо Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16.1-15.16.3-т заасан үйл ажиллагааг эрхлэх иргэн, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгоно.”

6/21 дүгээр зүйл:

“21 дүгээр зүйл.Дотоодын хэрэглээний холбооны сүлжээ

21.1.Аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо ашиглах зориулалтаар дотоодын хэрэглээний холбооны сүлжээ байгуулан ажиллуулж болно.

21.2.Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 21.1-д заасан сүлжээг ашиг олох зорилгоор бусдад ашиглуулахыг хориглох бөгөөд Зохицуулах хороо дотоодын хэрэглээний холбооны сүлжээнд зохицуулалт хийх журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавина.”

7/22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг:

“22.3.Харилцаа холбооны сүлжээ хоорондын харилцан холболт болон сүлжээнд холбогдох зааглах цэгийг Зохицуулах хороо тогтооно.”

8/25 дугаар зүйлийн 25.2.2 дахь заалт:

“25.2.2.харилцаа холбооны стандарт, техникийн нөхцөл, шаардлага, норматив баримт бичгийг мөрдөх, хуульд заасны дагуу баталгаажуулсан тоног төхөөрөмж ашиглах;”

4 дүгээр зүйл.Харилцаа холбооны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хамгаалахтай” гэснийг “хамгаалах, зах зээлийн үр өгөөжтэй, шударга өрсөлдөөнийг дэмжих, иргэн, хуулийн этгээдийг харилцаа холбоо, мэдээллийн технологийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хүртээмжтэй хангахтай” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “15.8.7-д заасан үйлчилгээ” гэснийг “15.16.1-15.16.3-т заасан үйл ажиллагаа” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын “баримтлах төрийн бодлого хэрэгжүүлэх” гэснийг “төрөөс баримтлах бодлогыг батлах” гэж, 6 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн “Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, дараахь

шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг Зохицуулах хорооны дарга, гишүүнээр томилно.” гэснийг “Харилцаа холбооны салбарт мэргэжлээрээ 10-аас доошгүй жил, түүнээс 3-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан, дараахь шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг Зохицуулах хорооны даргаар, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, дараахь шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг Зохицуулах хорооны гишүүнээр томилно.” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтын “бүрдүүлэх” гэснийг “бүрдүүлэхтэй холбогдсон журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “иргэний хамгаалалт” гэснийг “гамшгаас хамгаалах,” гэж, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “ажлын 10 хоногийн” гэснийг “30 хоногийн” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.14 дэх заалтын дугаарыг “6.1.18” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.14 дэх заалтын дугаарыг “9.1.17” гэж, 25 дугаар зүйлийн 25.2.10 дахь заалтын дугаарыг “25.2.13” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.11 дэх хэсгийн “Зохицуулах хорооны жилийн төсвийг Засгийн газар батална.” гэсэн 1 дэх өгүүлбэрийг хассугай.

6 дугаар зүйл.Харилцаа холбооны тухай хуулийн 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.1.11 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 14.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 10-12 дахь хэсэг нэмсүгэй:

“10.Нийтийн үйлчилгээний харилцаа холбооны сүлжээний хэвийн ажиллах нөхцөлийг хангаагүй, нийтийн үйлчилгээний харилцаа холбооны сүлжээг байрлуулах, харилцаа холбооны тоног төхөөрөмж дээр ажиллахад саад учруулсан бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Домэйн нэрийн үйлчилгээнд тавих нөхцөл, шаардлагыг зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



12.Дотоодын хэрэглээний холбооны сүлжээг ашиг олох зорилгоор бусдад ашиглуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.1.хуульд заасны дагуу баталгаажуулсан тоног төхөөрөмж ашиглаагүй, хэрэглэгчийг регистрийн дугаараар бүртгээгүй, бусад үйлчлэгчид ижил нөхцөлөөр үйлчлээгүй;”

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр баталсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “төв” гэсний дараа “болон төрийн захиргааны” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “Төрийн” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр баталсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “яамтай” гэснийг “яам, агентлагтай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр баталсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Шуудангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.12- 3.1.14 дэх заалт:

“3.1.12.“шуудангийн үндсэн сүлжээ” гэж төрийн өмчийн оролцоотой, бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэгч шуудангийн сүлжээг;

3.1.13.“шуудангийн үйлчилгээ” гэж үйлчлүүлэгчээс шуудангийн илгээмж хүлээн авч шуудангийн сүлжээгээр дамжуулан хаягласан эзэнд нь хүргэх нэгдмэл үйл ажиллагааг;

3.1.14.“үйлчлүүлэгч” гэж шуудангийн үйлчилгээг авч байгаа иргэн, хуулийн этгээдийг.”

2/6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалт:

“6.1.5.шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журам батлах;”



3/7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт:

“7.1.8.олон улсын шуудангийн байгууллагад Монгол Улсыг төлөөлөх, холбогдох санал, дүгнэлт боловсруулах, олон улсын байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;”

4/9 дүгээр зүйлийн 9.1.4- 9.1.6 дахь заалт:

“9.1.4.хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, зохицуулалтын баримт бичиг болон холбогдох журам батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;

9.1.5.шуудангийн харилцан холболтын журмыг баталж, хэрэгжилтийг хангуулах;

9.1.6.шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх;”

5/16 дугаар зүйлийн 16.3.5, 16.3.6 дахь заалт:

“16.3.5.өөрийн сүлжээг бусад үйлчлэгч холбогдоход нээлттэй байлгах;

16.3.6.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22.2-т заасны дагуу бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд хөрөнгө төвлөрүүлэх;”

6/17¹ дүгээр зүйлийн 17¹.2.3 дахь заалт:

“17¹.2.3.Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийг хариуцах.”

7/19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг:

“19.2.Шуудангийн илгээмжийг үйлчлүүлэгчид хүргэх хугацаагаар нь ердийн, буухиа гэсэн зэрэглэл тогтооно.”

8/25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг:

“25.3.Үнэ бүхий шуудангийн тэмдэгт маркыг үйлдвэрлэх, борлуулах, хадгалах бодлогыг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл.Шуудангийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “хууль тогтоомж нь” гэсний дараа “Иргэний хууль,” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтын “ажиллагаа” гэсний дараа “аюулгүй,” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “цаг үеийн” гэсний өмнө “хүн амд шуудан, хэвлэл хүргэх ажлыг зохион байгуулах,” гэж, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “тээврийн буудал,” гэсний дараа “орон нутгийн замын

пост, гүүр,” гэж, 17¹ дүгээр зүйлийн 17¹.1.2 дахь заалтын “журмын дагуу” гэсний дараа “үйлчлэгчдэд ижил нөхцөлөөр” гэж, 19 дүгээр зүйлийн гарчгийн “төрөл” гэсний дараа “, зэрэглэл” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Шуудангийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5 дахь заалт:

“3.1.4.“захидал” гэж тодорхой этгээдэд хаягласан, дугтуйлсан болон дугтуйлаагүй гар бичмэл, хэвлэмэл баримт бичиг агуулсан шуудангийн илгээмжийг;

3.1.5.“боодол” гэж тодорхой этгээдэд хаягласан, эд зүйлс агуулсан битүүмжлэгдсэн шуудангийн илгээмжийг;”

2/3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт:

“3.1.8.“шуудангийн хайрцаг” гэж шуудангийн илгээмжийг цуглуулах, хүргэхэд ашиглах зориулалтаар тодорхой цэгт байрлуулсан хэрэгслийг;”

3/3 дугаар зүйлийн 3.1.10, 3.1.11 дэх заалт:

“3.1.10.“шуудангийн нэгдсэн код” гэж үйлчлүүлэгчийн байршлыг тодорхойлсон тоо, эсхүл тоо, үсгийн хосолсон илэрхийллийг;

3.1.11.“шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч” гэж шуудангийн бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг;”

4/7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалт:

“7.1.5.үнэ бүхий шуудангийн тэмдэгтийн үйлдвэрлэлт, борлуулалт, дахин үнэлэлт, улсын фондын баяжуулалт, хадгалалт, хамгаалалтын журмыг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;”

5/10 дугаар зүйлийн 10.2.2 дахь заалт:

“10.2.2.үйлчлэгчийн боловсруулсан аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хот, тосгоны доторх шуудангийн илгээмж хүргэх хуваарь, чиглэлийг тухайн шатны Засаг дарга.”

6/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:

“14.1.Үйлчлэгч нь Зохицуулах хорооноос баталсан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын дагуу захиалгат илгээмжийн худалдаа эрхэлж болно.”



7/21 дүгээр зүйл:

“21 дүгээр зүйл.Улс хоорондын шуудангийн илгээмж

21.1.Улс хоорондын агаарын болон газрын шуудангийн үйлчилгээнд Монгол Улсын олон улсын гэрээ, үйлчлэгч хоорондын гэрээ, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

21.2.Улс хоорондын шуудангийн илгээмж гэдэгт хилийн чанадаас Монгол Улсад хүргэж байгаа, Монгол Улсаас хилийн чанадад илгээж байгаа, эсхүл дамжин өнгөрч байгаа шуудангийн илгээмж хамаарна.”

8/24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт:

“24.1.1.Галт зэвсгийн тухай хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.1.6-д заасан галт зэвсэг, сум, байлдааны зориулалттай галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан химийн хорт болон аюултай бодис, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэл;”

9/24 дүгээр зүйлийн 24.1.3 дахь заалт:

“24.1.3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 3.1.1, 3.1.4-т заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эд;”

10/25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг:

“25.2.Шуудангийн марк нь Монгол Улсын тусгаар тогтнолыг илэрхийлсэн, шуудангийн илгээмжийн төлбөр төлөгдсөнийг баталгаажуулсан, үнэ бүхий шуудангийн тэмдэгтийн төрөл.”

4 дүгээр зүйл.Шуудангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн гарчгийг “Шуудангийн төрөл” гэж, мөн зүйлийн 4.3 дахь хэсгийн “тогтооно” гэснийг “баталж мөрдүүлнэ” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын “бүсчлэлийн” гэснийг “шуудангийн нэгдсэн” гэж, 7 дугаар зүйлийн гарчгийн “Засгийн газрын гишүүний” гэснийг “төрийн захиргааны байгууллагын” гэж, мөн зүйлийн 7.1 дэх хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.2.1 дэх заалтын “Засгийн газрын гишүүн” гэснийг “төрийн захиргааны байгууллага” гэж, 7 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 7.1 дэх хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.2.1 дэх заалтын “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “бодлого боловсруулж хэрэгжүүлэх” гэснийг “журам баталж, хэрэгжүүлэх” гэж, 11 дүгээр зүйлийн гарчгийг “Шуудангийн сүлжээний ашиглалт” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “20 дугаар зүйлд заасан” гэснийг “9.1.6-д заасны дагуу тогтоосон” гэж, 13 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 13.2 дахь хэсгийн “Электрон” гэснийг “Цахим” гэж, 13.1, 13.2



дахь хэсгийн “электрон” гэснийг “цахим” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “орон нутгийн” гэснийг “аймаг, нийслэл, сум, дүүрэг,” гэж, 16 дугаар зүйлийн 16.3.3 дахь заалтын “журмын” гэснийг “шуудангийн үйлчилгээний чанар, үндэсний стандартыг хангаж байгаа” гэж, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийн “6.1.3-т” гэснийг “7.1.7-д” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх заалтын “Монгол Улсын болон гадаад улсын мөнгөн тэмдэгт” гэснийг “үндэсний болон гадаад валют” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтын дугаарыг “6.1.6” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтын дугаарыг “7.1.9” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын дугаарыг “9.1.7” гэж, 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалтын дугаарыг “16.3.7” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Шуудангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “шуудангаар” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын, 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын “шуудангийн үйлчилгээний давуу эрхийн бүс,” гэснийг, Зургадугаар бүлгийн гарчгийн “, хүргэх хугацаа” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Шуудангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 20 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 14.3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.4, 3.5 дахь заалт нэмсүгэй:

“3.4. шуудангийн сүлжээ байгуулах, өргөтгөх, татан буулгах тухай Зохицуулах хороо болон хэрэглэгчид урьдчилан мэдэгдээгүй;

3.5. өөрийн сүлжээг бусад үйлчлэгч холбогдоход нээлттэй байлгах үүргээ биелүүлээгүй;”

2 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 14.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тээврийн буудал,” гэсний дараа “орон нутгийн замын пост, гүүр,” гэж нэмсүгэй.



3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 14.3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтын дугаарыг “3.6” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА,
НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 дэх заалтын “Г” дэд заалтын “, шуудан солилцох, хүргэх хуваарь, чиглэлийг батлах” гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

**РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Радио долгионы тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.5, 3.1.6 дахь заалт:

“3.1.5.“богино зайн радио төхөөрөмж” гэж нэг, эсхүл хоёр чиглэлд радио холбоо хийх, бусад радио холбоонд нөлөөлөхгүй, нөлөөллийн хамгаалалт шаардлагагүй, бага энерги хэрэглэх радио нэвтрүүлэгчийг;

3.1.6.“радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж” гэж радио холбооны үйлчилгээнд хөндлөнгөөс зориудаар шуугиан үүсгэн дохио дарагч төхөөрөмжийг.”

2/5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт:

“5.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.”



3/5 дугаар зүйлийн 5.2.6-5.2.10 дахь заалт:

“5.2.6.үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт батлах;

5.2.7.радио долгионы төлөвлөлтийн бодлого, стратеги, шинэ технологи нэвтрүүлэх, хөгжүүлэхэд баримтлах чиглэл батлах, хэрэгжилтийг хангуулах;

5.2.8.Монгол Улсад хуваарилсан сансрын холбооны хиймэл дагуулын байрлалыг ашиглах талаар санал боловсруулах;

5.2.9.тусгай хэрэглээнд ашиглах радио давтамжийн зурвасын нэгдсэн төлөвлөлтийг батлах;

5.2.10.хуульд заасан бусад бүрэн эрх.”

4/5¹ дүгээр зүйл:

“5¹ дүгээр зүйл.Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрх

5¹.1.Харилцаа холбооны зохицуулах хороо радио долгионы талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5¹.1.1.радио долгионы талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, хэрэгжилтэд нь дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;

5¹.1.2.радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх, радио давтамжид баримтлах зохицуулалт, радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норматив баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

5¹.1.3.улс орны зайлшгүй хэрэгцээ болон техник, технологийн шинэ дэвшлийг нэвтрүүлэхэд шаардагдах радио давтамжийн зурвасын судалгаа хийх, нөөцийг бүрдүүлэх;

5¹.1.4.Монгол Улсад радио долгионы хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх;

5¹.1.5.Монгол Улсад бүртгэлтэй радио давтамж, радио давтамжийн зурвасыг олон улсын цахилгаан холбооны байгууллагад бүртгүүлэх;

5¹.1.6.тусгай хэрэглээнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалтыг тусгай хэрэглээний радио давтамж ашиглах эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулах;



5¹.1.7.цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшний хэмжилт хийх аргачлалыг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

5¹.1.8.хуульд заасан тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, тохирлын гэрчилгээ олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

5¹.1.9.радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах журам батлах, хяналт тавих;

5¹.1.10.энэ хуулийн 5.2.3-т заасан журмын дагуу радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээг батлах;

5¹.1.11.хуульд заасан бусад бүрэн эрх.”

5/6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг:

“6.4.Нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасын хуваарилалт, төлөвлөлт нийтэд нээлттэй байна.”

6/8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэг:

“8.2.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд тохирлын баталгаагүй радио тоног төхөөрөмж ашиглахыг хориглоно.

8.3.Хуульд өөрөөр заагаагүй бол радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах, импортлох, үйлдвэрлэх, худалдахыг хориглоно.”

7/15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг:

“15.3.Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн нэгдсэн бүртгэлийн журмыг харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.”

8/20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэг:

“20.6.Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журмыг Зохицуулах хороо баталж, мөрдүүлнэ.”

2 дугаар зүйл.Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “долгионы” гэсний өмнө “радио” гэж, мөн зүйлийн 5.2.5 дахь заалтын “төлөөлөх” гэсний дараа “, гишүүн орнуудаас урьдчилан гаргасан санал, дүгнэлт, судалгааны үр дүнг судлах, олон улс, бүс нутгийн хуралд бэлтгэх, оролцохтой холбогдсон ажлыг зохион байгуулах;” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “аюулгүй байдлыг хангах,” гэсний дараа “гамшгаас хамгаалах,” гэж, 8 дугаар

зүйлийн гарчгийн “зурвас” гэсний дараа “, радио төхөөрөмж” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2.2 дахь заалтын “тухайн” гэсний өмнө “Харилцаа холбооны тухай хуулийн 14.2-т заасан үндэслэлээр, эсхүл” гэж, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “стандартын дагуу” гэсний дараа “баталгаажуулалт хийх ба баталгаажуулалтын” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Радио долгионы тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт:

“5.2.3.радио давтамжийн зурвасыг ашиглах, төлөвлөх, дахин төлөвлөх, хуваарилах болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр тогтоох журам батлах;”

2/14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалт:

“14.1.3.техникийн шаардлага хангасан, тохирлын гэрчилгээтэй богино зайн радио төхөөрөмж.”

4 дүгээр зүйл.Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “9.2-т” гэснийг “13.2-т” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “11-д заасны дагуу ашиглана” гэснийг “11.1-д заасны дагуу ашиглах зөвшөөрөл олгоно” гэж, 11.4 дэх хэсгийн “өрсөлдүүлэн” гэснийг “сонгон” гэж, мөн хэсгийн “олгож болно” гэснийг “олгоно” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “15” гэснийг “20” гэж, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “11-д” гэснийг, “15.1-д” гэж, 18 дугаар зүйлийн гарчгийн болон 18.2 дахь хэсгийн “цуцлах” гэснийг “хүчингүй болгох” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “12-т” гэснийг “15.1-д” гэж, мөн зүйлийн 18.1, 18.5 дахь хэсгийн “цуцална” гэснийг “хүчингүй болгоно” гэж, 18.6 дахь хэсгийн, 19 дүгээр зүйлийн 19.2.7 дахь заалтын “цуцалсан” гэснийг “хүчингүй болгосон” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “төв” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, мөн зүйлийн 5.2.4 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 14.2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7 дахь хэсэг нэмсүгэй:

“7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл болон түүнд заасан эрх, үүргээ тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлсэн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2021-2022 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2020 он	2021 он	2022 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	6.0	6.0	6.0
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	8.0	8.0



3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	11,122.6	12,070.3	12,908.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	27.3	26.3	25.0
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	13,197.4	13,333.2	13,637.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.4	29.1	26.4
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	1,608.3	135.8	304.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	4.0	0.3	0.6
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,074.7	-1,262.9	-728.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-5.1	-2.8	-1.4
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	3,491.4	2,935.8	2,823.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	8.6	6.4	5.5
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	22,089.1	22,910.5	23,869.2
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	54.3	50.0	46.2
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	750.2	810.2	875.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.8	1.8	1.7

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 06 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН БОЛОН ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНД БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2004 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр баталсан “Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын болон Оросын Холбооны Улсын Засгийн газрын хооронд байгуулсан хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 06 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ПРОТОКОЛ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2015 оны 10 дугаар сарын 22-ны өдөр баталсан Монгол-Оросын “Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2003 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын протоколыг соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 06 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ПРОТОКОЛ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2015 оны 10 дугаар сарын 22-ны өдөр баталсан Монгол-Оросын “Монголросцветмет” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2007 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын протокол соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 06 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Монгол Оросын “Монголросцветмет” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 06 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2019 оны 5 дугаар сарын 09-ний өдөр баталсан Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 3.1.7 дахь заалт, тайлбарыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалт, тайлбар:

“3.1.7. Монгол Улсын Их Хурлын улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас гаргасан шийдвэр.

Тайлбар: “Улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор” гэдэгт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд заасан онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас гаргасан төрийн гадаад, дотоод бодлогыг тодорхойлсон шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор, Улсын Их Хурлын тухайн шийдвэрээс салгаж болохгүй Засгийн газрын шийдвэрийг ойлгоно.”

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1,5

Индекс: 200003